



**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

┌ 2026 оны нийгмийн баталгаа болон ┐
сургалтын төлөвлөгөө батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Засгийн газрын 2015 оны 72 дугаар тогтоолоор баталсан Цөмийн энергийн комиссын дүрмийн 6.3, Ажлын албаны даргын баталсан 2026 оны А/05, А/06 дугаар тушаал, Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус Ажлын албаны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх албан хаагчдын 2026 оны нийгмийн баталгааны арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, албан хаагчдын 2026 оны сургалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. 2026 оны нийгмийн баталгааны болон сургалтын төлөвлөгөөг байгууллагын төсөвт тусгагдсаны дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн бөгөөд Ахлах нягтлан бодогч (П.Номин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Б.Баатарцогт), Цөмийн технологийн бодлогын газар (М.Чадраабал), Цөмийн аюулгүй байдлын бодлогын газар (Э.Нямдаваа)-т тус тус даалгасугай.

ДАРГА



МАНЛАЙЖАВ

1726010053

Цөмийн энергийн комиссын Ажлын
албаны даргын 2026 оны 02 дүгээр
сарын 22-ны өдрийн 111 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

1117134505 УХА0230
5952506

2026 ОНЫ АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж	Тайлбар
Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, ажлын байрны нөхцөл, баталгааны чиглэлээр				
1.	Хүүхдийн өрөө шийдвэрлэх өгөх	I-IV улирал	ТГ, ЦТБГ, ЦАББГ	Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлөөс 2019 онд “Төр, хувийн байгууллага бүр хүүхдэд зориулсан өрөө эсвэл буланг тохижуулах”-ыг уриалж, Монгол Улсын Ерөнхий сайдаас үүрэг чиглэл өгч байсан
2.	Ажлын байрны ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, нийт албан хаагчдын хэрэглэж байгаа сандалыг сольж орчин үеийн оффисын шаардлагад нийцүүлж амьсгалдаг нуруу амраагчтай сандалаар хангах	I-IV улирал	ТГ	Төрийн албаны тухай хуулийн 61.1.2 дах заалт, “Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.3.1, 4.3.2 дахь заалтууд,
3.	Орчин үеийн шаардлага хангасан компьютер, таблет, хэвлэх төхөөрөмжөөр хангаж, техникийн шинэчлэлийг үе шаттайгаар хийх	I-IV улирал	ТГ	Төрийн албаны тухай хуулийн 61.1.2 дах заалт, “Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.3.1, 4.3.2 дахь заалтууд,
Нөхөх олговор олгох, хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр				
4.	Цацрагтай ажиллагчдийн хэвийн бусын нэмэгдэл хөлс /39,000төгрөг/-ийг нэмэгдүүлэх	I-IV улирал	ТГ, ЦАББГ	Холбогдох хууль, дүрэм, журамд шаардлагатай зүйл заалтыг тусгуулах арга хэмжээг авах, хэрэгжилтийг хангах
5.	Цацрагтай ажиллагсадыг хортой нөхцөл руу оруулах асуудлыг шийдвэрлэх талаар арга хэмжээ авах	I-IV улирал	ТГ, ЦАББГ	Холбогдох хууль, дүрэм, журамд шаардлагатай зүйл заалтыг тусгуулах арга хэмжээг авах, хэрэгжилтийг хангах
Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдралын нөхцөлийг сайжруулах чиглэлээр				

6.	Орон сууцны ипотекийн зээлд хамрагдах албан хаагчдын 30 хувийн урьдчилгааг зээлийн батлан даалтын санд хамрагдах нөхцөлийг бүрдүүлэх	I-IV улирал	ТГ	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “9.1.3. Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдэд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэж заасан.
7.	Албан хаагчдын зуслангийн газрыг шийдвэрлэх	I-II улирал	ТГ	“Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.7.1.7 дахь заалт,
8.	Албан хаагчдийг ажлын 5 өдрийн 1 өдөр нь цахимаар ажиллах боломжоор хангах	I улирал	ТГ	Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.3.Ажлын зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн албан хаагчийг ажлын нэг өдөр зайнаас ажиллуулна” гэж заасан.
Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр				
9.	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг оношлогоонд нэгдсэн журмаар хамруулна	I улирал	ТГ	“Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.9.1 дэх заалт,
10.	Хавар, намар, идэвхтэй амралт, явган болон тойрон аялалыг зохион байгуулна.	II, IV улирал	ТГ,ЦАББГ,ЦТБГ	“Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.9.4 дэх заалт,
11.	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилтнуудын дунд спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, долоо хоногийн нэг өдөрт спорт зааланд тоглуулдаг байх/ гэрээ байгуулах/	I-IV улирал	ТГ	“Цөмийн энергийн комиссын ажлын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 4.9.2 дахь заалт,

Цөмийн энергийн комиссын
Ажлын албаны даргын 2026 оны 02
дүгээр сарын 12-ны өдрийн А.М.
тушаалын 2 дугаар хавсралт



ЦӨМИЙН ЭНЕРГИЙН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН
2026 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	хугацаа	Хамрагдах Хүрээ	Санхүүжилт	Хариуцах нэгж	Тайлбар
1.	Анх төрийн албанд томилогдож орсон албан хаагчдад зориулсан сургалт	I-IV	Шинээр томилогдсон албан хаагчид	-	Ёс зүйн дэд хороо, ТГ	
2.	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт	I-IV	Нийт албан хаагчид	-	Ёс зүйн дэд хороо	
3.	Худалдан авах ажиллааны АЗ сургалт	I-IV	Албан хаагчид	Байгууллагын төсөв	ЦАББГ	
4.	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт	IV	Албан хаагчид	Байгууллагын төсөв	ТГ	
5.	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт	IV	Албан хаагчид	Байгууллагын төсөв	ТГ	